

Нөгөө талаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйт харилцааг төлөвшүүлэхэд дээр дурьдсан асуудлуудын хүрээнд холбогдох арга хэмжээг авахаас гадна ёс зүйн талаарх мэдлэгийг эзэмшүүлэх, төлөвшүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйг бусад хууль сахиулах байгууллагуудын ёс зүйн хэм хэмжээтэй харьцуулан судлаж сургалт, сурталчилгааг тогтмолжуулахад анхаарах;
2. Ёс зүйн зарим нэг алдааны мөн чанарыг нээн алдаа гаргасан нөхцөл байдлыг нарийвчлан судлах;
3. Ёс зүйн хэм хэмжээг зөрчих үйлдэл, эс үйлдхүйгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах /харилцааны түвшинг тогтоож гэмт санаа бодлыг ухамсарлуулан арилгах арга хэмжээ авах гэх мэт/;
4. Ёс зүйн хэвийн харилцаанд сөрөг хүчин зүйл үүсгэх буй хорих ял эдлэгсдэд хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх арга хэмжээг төгөлдөржүүлэх;
5. Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжиж эхлэхэд бэлтгэх ажлыг нарийвчлан хангах;
6. Хууль сахиулагчийн ёс зүйн асуудалд онцгой анхаарах зэрэг саналыг дэвшүүлж байна;



Э.БААТАРХҮҮ

Багануур дүүрэг дэх
Шийдвэр гүйцэтгэх
албаны хорих 427-р
ангийн ерөнхий
жижүүр, ахмад

ТУСГААРЛАХ ТАСАЛГАА, САХИЛГЫН ХОРИХ БАЙРАНД ЯЛТНЫГ БАЙЛГАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ

Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих байгууллагад хоригдож байгаа хоригдогч, ялтны дотроос гэмт хэрэг үйлдэх, нийгэм ард иргэдийг гэмт халдлагад өртөхөөс хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тусгаарлах тасалгаа, сахилгын хорих байрны тухай авч үзэхийн тулд юун түрүүнд ялгааг нь гаргах нь зүйтэй гэж үзлээ. Хууль тогтоомж, хорих ангид тогтоосон дотоод дэглэм журам зөрчиж сахилгын арга хэмжээ авагдсан ялтныг тусгаарлан хорих өрөөг *сахилгын байр*, хорих анги, ялтны аюулгүй байдлыг хангах тэдний зүгээс гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор ялтныг 72 цаг хүртэл түр хугацаагаар шилжүүлэх өрөөг *тусгаарлах тасалгаа* гэнэ⁸⁰.

Юуны өмнө хорих ял эдлэгсдийг тусгаарлах тасалгаанд шилжүүлэх, сахилгын хорих байранд хорих үндэслэл нь юу болох талаар энд дурьдах нь зүй ёсны хэрэг. Нийгэмд амьдарч тодорхой төрлийн эрх зүйн харилцаанд оролцож буй бүх этгээд нийгмийн харилцааны хэм

⁸⁰Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 12 дугаар сарын 08 өдрийн А/229 дүгээр тушаал

хэмжээг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага болон жам ёсны хариуцлага хүлээдэг нь эргэлзээгүй билээ. Тэгвэл нийгэмд тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэж нийгмээс тусгаарлагдаж хорих ялаар шийтгүүлсэн этгээд хууль тогтоомж, хорих ангид тогтоосон дэглэм, журам зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй бол түүнд хорих ангийн даргын шийдвэрээр сахилгын шийтгэл оногдуулж сахилгын хорих байранд хорих тушаал гаргаж сахилгын байранд хорино. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах, гарч болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, ялтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хорих анги, албаны гүйцэтгэх ажилтан, дэглэм харуул хамгаалалтын байцаагч, ерөнхий жижүүр нь үндэслэл бүхий тогтоол үйлдэж, 72 цаг хүртэл хугацаагаар ялтанг тусгаарлах тасалгаанд түр шилжүүлнэ.

Ялтныг тусгаарлах тасалгаанд түр шилжүүлэх үндэслэлийг авч үзвэл:

- Гэмт хэрэг үйлдсэн, ноцтой зөрчил гаргасан, гэмт хэрэг, ноцтой зөрчлийн талаар худал мэдүүлэг өгөхөөр үгсэн тохирохоос урьдчилан сэргийлэх
- Бусдыг алах буюу бие эрхтэнд нь гэмтэл учруулахаар заналхийлсэн, эсхүл тухайн ялтны аюулгүй байдалд эрсдэл учирсан
- Өөрийн бие эрхтэнд санаатайгаар гэмтэл учруулсан, амь насаа хорлохыг завдсан, яриа өгүүлэл гаргасан.
- Оргох болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хорих анги, албаны аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангах зорилготой байна.

Ялтанд сахилгын шийтгэл оногдуулж сахилгын хорих байранд хорьж буй гол зорилго нь: **нэгдүгээрт:** бусад ялтнуудыг сахилгын зөрчил гаргуулахгүй байх талаар авч буй урьдчилан сэргийлэх арга хэмжээ, **хоёрдугаарт:** ялтны гаргасан зөрчилд хүлээлгэж буй хариуцлагын нэг төрөл,

гуравдугаарт: тухайн ялтныг гаргасан зөрчилд нь гэмшүүлж цээрлүүлэх явдал юм.

Сахилгын хорих байр, тусгаарлах тасалгааны хэвийн үйл ажиллагааг хангах нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг, чиглэлтэй салшгүй холбоотой юм. Өөрөөр хэлбэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг нь хорих ангийн хэвийн үйл ажиллагааг хангах явдал юм. Үүнд хэвийн үйл ажиллагааг хангагдсан байдал гэдэгт юуны түрүүнд ялтны зүгээс үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, ноцтой гэмт зорилго бүхий нуугдмал санаа, төлөвлөлтийг илрүүлэх арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байхыг ойлгоно. Үүний зэрэгцээ хорих ангийн барилга байгууламж, хамгаалалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн байнгын найдвартай ажиллагаа, санхүүгийн болон бусад материаллаг хангамж тасралтгүй хангагдсан байдал зэрэг нь хорих ангийн сахилгын хорих байр, тусгаарлах тасалгааны хэвийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгүүд болно.

Мөн хорих ангийн сахилгын хорих байр, тусгаарлах тасалгааны хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй анхаарвал зохих нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын боловсон хүчний хангамж, ажилтан албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, анхан шатны болон давтан сургалт түүний үр дүн гэж үзэж болно. Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол улсын хууль тогтоомжид зааснаар “Төрийн нууц”-тай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлдэг “Төрийн тусгай алба” болохын хувьд байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь энэ зорилтын хүрээнд хэрэгжинэ. Хоригдолд үзүүлэх албадлагын арга хэмжээнд тэдэнд тавих

бүх талын хяналт харуул хамгаалалт болон зайлшгүй тохиолдолд оногдуулах сахилгын шийтгэлийг хамааруулан ойлгож ирсэн байна.⁸¹

Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хорих ял шийтгүүлэн хорих байгууллагын мэдэлд ирээд суллагдах хүртэл бүх хугацаанд хоригдлыг бие болоод амьдрах байр, хөдөлмөрлөх орчинд төрөл бүрийн хяналт тавьдаг. Ялтан хоригдох хугацаанд байнгын харуул хамгаалалтын хатуу чанд нөхцөлд байлгадаг гэж зарим эрдэмтэд бүтээлүүддээ дурьдсан байдаг.⁸²

Хоригдолд албадлагын арга хэмжээ хэрэглэх тодорхой хугацаанд тэдний сахилгын зөрчил гаргасан, гэмт хэрэг үйлдсэн байдалд тохирсон аливаа сахилгын арга хэмжээ, эрүүгийн болон материаллаг хариуцлага ноогдуулж түүнийгээ эдлүүлж эхлээд дуусгах хүртэлх хугацаа хамрагдана. Тухайлбал: Хоригдлыг сахилгын хорих байр, тусгаарлах тасалгаанд хорихдоо Улсын ерөнхий прокурортой зөвшилцож, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан гаргасан журмыг баримтлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог.

Сахилгын хорих байранд ялтан нь ямар нэг байдлаар зөрчил гаргаж хоригдож байгаа ба энэ нь хорих ангийн

хэвийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг гэж үзэж болно. Тухайлбал хорих ангид ял эдэлж буй ялтны хөдөлмөрлөх, хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагааг хорих анги, ангийн удирдлага, албан хаагчид шууд хариуцан явуулдаг бөгөөд ялтны гаргасан зөрчлөөс хамааран тухайн ялтны ажлын байр эзгүйрэх, тус ангийн хэвийн үйл ажиллагаа доголдох, зэрэг асуудлууд үүсдэг. Иймд ялтны зөрчил гаргах шалтгаан, гаргасан зөрчлийн хор аюул хамрах хүрээнээс шалтгаалан хорих ангийн даргын тушаалаар сахилгын шийтгэл оногдуулдаг. Оногдсон сахилгын шийтгэлийн арга хэмжээний нэг болох сахилгын хорих байранд хорих явдал нь тухайн ялтныг гэмшүүлэх дахин зөрчил гаруулахгүй байх талаар ойлгуулах, түүгээр дамжуулан бусад ялтны сэтгэл зүйд нөлөөлж, цочрол өгөх зэрэг олон талын ач холбогдол агуулдаг боловч практик үйл ажиллагаан дээр энэ нь хэрэгжихгүй байгаатай холбоотой ялтны дундаас гарах зөрчил болон гэмт хэрэг буурахгүй байгаа билээ.

Мөн хорих ял эдлэгсдийн бүтцэд судалгаа хийж үзвэл 2013 оны жилийн эцсийн байдлаар нийт 6900 гаруй ялтан хорих ял эдэлж байгаагаас 50 гаруй хувь нь 15 ба түүнээс дээш жилийн ялтай, 35% нь хүнд, онц хүнд, тэр дотроо хүчирхийлэлийн гэмт хэрэг үйлдсэн, 70% нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, 49,4% нь хоёр ба түүнээс дээш удаа хорих ял эдэлж байгаа /3-аас дээш удаа ял эдэлж байгаа ялтан нийт ялтны 15 % -ийг эзэлдэг/⁸³ ялтнууд байгаа нь хорих ял эдлэгсдийн дотроос гарах зөрчил их байгаа ба энэ нь тусгаарлах тасалгаа, сахилгын хорих байранд хоригдох ялтны тоо ихсэх хандлагатай байна. Мөн сүүлийн арван жилийн байдлаар төвлөрсөн хорих ангиудад нийт 5998 ялтан зөрчил гаргаж сахилгын шийтгэл

⁸¹ А.Лхагваа. Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ 2008 он., 234 дэх тал

⁸² С.Нарангэрэл, БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүйн үндсэн асуудал., УБ. 1985 он.

- А.Лхагваа. Засан хүмүүжүүлэх байгууллагад хорих ял эдлэгсдийн хөдөлмөр зохион байгуулалт, түүний эрхийн асуудал., УБ. 1989 он.

- А. Лхагваа, С.Жанцан. Монгол улсын эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй., УБ. 1999 он.

- А. Лхагваа, Х.Пүрэвсүрэн. Монгол улсын эрүү, иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэрийг биелүүлэх хууль тогтоомжын хөгжилт., УБ. 2005 он.

- Д. Дашзэвэг. Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй., УБ. 2004 он.

⁸³ ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын 2013 оны тайлан

эдэлсэн байна. Үүнээс үзэхэд 30% гаруй хувьд нь гар утас ашигласан зөрчил зонхилж байгаа бөгөөд албан хаагчийн шаардлага биелүүлээгүй 844, архи болон согтууруулах ундааны зүйлс хэрэглэсэн 1060, хорих ангийн дотоод журам зөрчсөн 479, бусдын биед гэмтэл учруулсан 474 ялтан гэх зэрэг зөрчлүүд зонхилж байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн байдлаар ялтны гаргасан зөрчилд оногдуулсан сахилгын арга хэмжээ жил жилээр огцом өсч байгаа нь судалгаагаар харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд ялтны эрхийг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн бодлогууд ихээр явагдаж хорих анги болон бусад салбар нэгжүүдэд ялтны эрхийг хангах хамгаалах олон талын үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагууд хэржүүлж ирсэн бөгөөд үүнтэй холбоотой ялтанд оногдуулах сахилгын шийтгэлийн асуудал хөндөгдөж байсан юм.

Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 127 дугаар зүйлд ялтанд оногдуулах сахилгын шийтгэл болон сахилгын хорих байрны талаар хуульчилж эрх зүйн зохицуулалт хийгдсэн байдаг.

Ялтан хууль тогтоомж, хорих ангид тогтоосон дэглэм, журам зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй бол түүнд хорих ангийн даргын шийдвэрээр дараах сахилгын шийтгэл оногдуулдаг. Үүнд:

- Ээлжийн бус ажил хийлгэх
- Хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх
- *Сахилгын байранд хорих*
- Тухайн улирал эсхүл жилд олгосон шагналын хоногийг хасах.

Хорих ял эдлүүлэх дэглэм нь ялтныг хүмүүжүүлэхэд нөлөөлөөд зогсохгүй хорих анги, гяндан, баривчлах байранд ялтнуудаас гэмт хэрэг шинээр үйлдэхээс урьдчилан сэргийлэх явдлыг хангана.

Хорих ял эдлүүлэх дэглэм нь, ялын цээрлэл үзүүлэх, шууд илэрхийлэл болохын хувьд иж бүрэн эрхийн хязгаарлалтуудад илэрч байдаг. Ялтны эрхийн байдлыг тодорхойлдог. Энэ байдал нь ялтан хорих ял эдэлж байх хугацаандаа иргэний эрхээ бүрэн эдлэх боломжоо хязгаарлуулж байгаа нь ялын цээрлэл амсаж байгаа хэрэг юм.

Дэглэмийн тусламжтайгаар ялын цээрлэлийг хэрэгжүүлэх нь гол зорилго гэж үздэг. Цээрлэл нь аливаа эрүүгийн ялд байх элемент бөгөөд энэ нь гагцхүү хүмүүжүүлэх агуулгатай юм. Өөрөөр хэлбэл ялтанд цээрлэл үзүүлэх замаар дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байлгахад Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан нэг зорилго оршино.

Эрхийн хязгаарлалтууд нь цээрлэлийн агуулгатай боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн нөлөөллийн бусад арга хэмжээнүүдтэй нягт холбоотойгоор хэрэгжиж, хорих ял эдлэгсэдийг нийгэмд тогтоосон нийтээр дагаж мөрдөх хууль ёсыг сахин биелүүлдэг, аливаа асуудалд тэвчээртэй ухаалаг ханддаг болгон ялтныг хүмүүжүүлдэг болохыг практик харуулж байна. Үүнээс үндэслэн дэглэмийг зөвхөн ялтныг цээрлүүлэх хэрэгсэл гэж үзэж болохгүй бөгөөд дэглэм нь бүхэлдээ тэдний үйлдсэн гэмт хэрэг, зан байдлын хувьд харилцан адилгүй олон тооны ялтнуудыг нэг дор амьдрах нөхцөлийг бүрдүүлээд зогсохгүй, ялтан бүрийн алхам тутамдаа биеэ авч явах журам, амьдралын хэв маягийг нарийвчлан тогтоох замаар тэднийг хамтын хөдөлмөр хийлгэж, улмаар хөдөлмөрөөр хүмүүжүүлэх, тэдний дунд хүмүүжлийн ажил, боловсролын сургалт, хөдөлмөрийн дадлага олгох сургалт зохион байгуулах нөхцөлийг хангаж байдгаараа хүмүүжлийн чухал хэрэгсэл юм. Олон хүн цугларсан газар тэр тусмаа гэмт хэрэгтнүүдийн бөөгнөрөл болсон хорих байгууллагад хатуу дэг журамгүйгээр ялын зорилго хангагдахгүй харинч

тэдний дундаас гарах зөрчил гэмт хэрэг гарах нөхцөл бололцоог олгож буй хэрэг гэдгийг 90 жилийн түүхэн туршлага харуулж байна.

Хорих ял эдлэгсдийг тусгаарлах тасалгаа, сахилгын хорих байранд хорихгүй байж тэдний тоог бууруулахын тулд ялтны дундаас гарч буй зөрчлийг бууруулах гол үндсэн арга юм энэ нь ялтныг хүмүүжүүлж, нийгэмшүүлэх явдал юм. Хорих ангийн нөхцөлд ялтныг хүмүүжүүлэх гол арга бол хөдөлмөрлүүлэх нь зөв оновчтой арга боловч үүний зэрэгцээ хорих ангитай хамтарч үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын оролцоо асар их юм жишээлбэл ялтны сэтгэл зүйд нөлөөлж чаддаг бясалгал болон христийн сургалтууд нь байж болох юм. Тус сургалтууд нь явагдсанаар хэрэг зөрчил гаргадаг ууртай омогтой ялтнууд нь өөрсдийгөө захирч удирдах чадвартай болох ба нийгэмд гараад ч мөн чиглэлээрээ сургалтанд хамрагдаад амьдралд хөлөө олсон тохиолдол багагүй байдаг.

Эрүүгийн хуулийн тодорхой нийгэмд аюултай, эс аюултай үйлдлийг хийж бусдад ямарваа нэгэн хэлбэрээр эд материалын болон сэтгэл санааны хохирлыг их, бага хэмжээгээр учруулж, үүний улмаас Үндсэн хуульд заасан заяамал эрхээс бусад тодорхой эрхүүдийг хязгаарлаж, төрийн хуулийн дор суугаа этгээдийн талаарх анхаарах зарим асуудлуудыг авч үзэх нь зүйтэй. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгчийн хувьд шийтгэх тогтоол гарсан бол “ялтан” гэж нэрлэх болсон. Тухайн ялтныг хорьж цагдсанаар гэмт үйлдлийг ойлгуулах, нийгмийн хор уршиг аюулыг бүрэн гүйцэт таниулах, цаашид дахин гэмт хэрэг үйлдэхгүй гэх баталгаа бүрэн хангагдаж чадахгүй байна. Тухайлбал гэмт хэрэг үйлдээд нийгмээс тодорхой эрхээ хасуулан хорих газар орж ирсэн мөртлөө хорих газраа зөрчил гаргах

дахин гэмт хэрэг үйлдэж бусад ялтнуудаасаа тусгаарлагдах тохиолдол их гарах болсон. Өнөөгийн нийгэм дэх бодит байдал дээр энгийн буюу эрх чөлөөт иргэдээс авахуулаад нийгмийн тодорхой хэсэг, бүлэг хүмүүст ажлын байр олдохгүй, олдсонч тухайн ажлын байранд ажлын дадлага туршлага, нас, мэргэжил, боловсрол зэрэг наад захын шалгуур үзүүлэлтийг тавьж, үүнийг хангах шаардлага гарч байна. Энэ нь зах зээлийн бичигдээгүй хуулийн дагуу тавьж буй тодорхой хэрэгцээнд тулгуурласан ойлголт билээ. Мөн хувь хүний өөрийн мөн чанар, ажилд хандах хандлага, өөртөө тавьсан зорилго, хэтийн төлөвлөлт, гэр бүлийн орчин, найз нөхдийн хамаарал, ажил олгогчоос олгож буй цалин хөлс зэрэг нь хангалтгүй сөрөг нөлөөлөл үзүүлж байдаг. Энэ бүхэн гэмт хэрэг үйлдэх шалтгаан нөхцөл болж нэг хэсгийг нь хохироох, нөгөө хэсгийг нь ялтан хэмээх нэрийн дор ял эдлүүлж байна. Иймд хорих ангид ял эдэлж буй ялтан этгээдийг зүгээр суулгаж тэжээх нь гол биш өнөөгийн нийгмийн тавьж байгаа зорилтод нийцүүлэн хөдөлмөрлүүлэх нь оновчтой, нөгөө талдаа төрийн албадлагын нэг хэлбэр хэрэгжиж байх ёстой.

Түүнчлэн хорих ангиуд нээлттэй, хаалттай хорих ангийн төрөл дэглэмд шилжиж байгаатай уялдуулан эртнээс ялтны ялын байдлыг харгалзан мэргэжил боловсролтой болгох, ажлын дадлага чиг баримжаа олгох сургалтуудыг зохион байгуулах, шинээр үйлдвэрлэлийг эхлүүлэх бололцоотой тохиолдолд гаднаас хөрөнгө оруулагч нарыг дэмжих, тодорхой хугацааны дараа тухайн тоног төхөөрөмж үйлдвэрийг өөрийн болгох, цаашилбал улс орны томоохон бүтээн байгуулалтанд ялтныг татан оролцуулах. Энэ бүхэн нийгэм эдийн засгийн хувьд чухал ач холбогдолтой бөгөөд бие хүн болох ялтны эрх ашигт эерэгээр нөлөөлж нийгэмшүүлэхэд үр дүнгээ өгч ялтны

дундаас гарах зөрчил их бага аль нэг хэмжээгээр буурах нь зайлшгүй юм.

Тусгаарлах тасалгаа, сахилгын байр нь гадаадын зарим оронд дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ремшайдын хаалттай хорих анги нь сахилгын зөрчил гаргасан ялтанд арга хэмжээ авахдаа эхлээд сануулдаг ба цаашлаад сахилгын байранд 30 хүртэл хоног хорьдог байна. Мөн сахилгын хорих өрөөнд ганцаарчлан хорих ба зөвхөн “Библи” номтой байхыг зөвшөөрдөг байна. Тусгаарлах өрөө амиа хорлох аюултай, өөрийгөө хянах чадваргүй болсон хоригдлыг хорьдог. 3-аас илүү хоног хорих болвол Хууль зүйн яаманд мэдэгдэх үүрэгтэй, эмнэлгын ажилтан хажууд нь бэлэн байх ба хяналтын шилэн цонхоор хяналт тавина. Нэмэлт хэрэгсэл нь хүлж тогтоодог ор байна.

Манай улсын хувьд шууд сахилгын хорих байранд хорьдог ба ямар нэгэн ном болон бусад унших зүйл оруулахыг хориглодог байна. Мөн дээд хугацаа нь шаардлагатай тохиолдолд 60 хүртэл хорино гэж заасан. Тусгаарлах тасалгаанд 72 цаг хүртэл хорино гэж заасан байдаг ба амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах тохиолдолд тусгай хэрэгсэл хэрэглэнэ гэж заасан байгаа.

Орсын холбооны улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд ялтныг тусгаарлах тасалгаанд хорих талаар дараах байдлаар тусгагдсан байна. Ялтан тогтоосон дүрмийг санаатайгаар зөрчсөн жирийн буюу чанга дэглэмтэй эрэгтэй хоригдогсдыг тусгаарлах тасалгаанд, харин онцгой дэглэмтэй эрэгтэй хоригдогсдыг ганц хүний камерт 6 сар хүртлэх хугацаагаар тус тус хорих, дүрмийг ноцтойгоор зөрчсөн эрэгтэй хоригдогсдыг тусгаарлах тасалгаанд нэг жил хүртлэх хугацаагаар хорих, дүрмийг ноцтойгоор зөрчсөн эмэгтэй хоригдогсдыг тусгаарлах тасалгаанд

гурван сар хүртлэх хугацаагаар хорих гэж заасан байна.

Манай улсын хувьд ялтныг 72 цаг хүртэл тусгаарлах тасалгаанд хорих ба насанд хүрсэн эрэгтэй ялтныг 30 хүртэл хоног, насанд хүрээгүй болон насанд хүрсэн эмэгтэй ялтныг 15 хүртэл хоног, онцгой тохиолдолд насанд хүрсэн эрэгтэй ялтанг 60 хүртэл хоног, насанд хүрээгүй болон насанд хүрсэн эмэгтэй ялтанг 30 хүртэл хоног сахилгын байранд хорино гэж заасан байгаа нь хорих хоногын хувьд асар их ялгаатай байна. Иймээс дээрх ялгаатай байдлыг багасгах, олон улсын жишигт нийцүүлэн эрх зүйг орчин нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай гэж судлаачын зүгээс үзэж байна.